

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРААС НИЙТИЙН ӨМЧИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ

2025 оны 04 сарын 23-ны өдөр

Нийтийн өмчийн тухай хуулийн төсөлд дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

№	Нийтийн өмчийн тухай хуулийн төсөл:	Санал: Нэмэх, Өөрчлөх, Хасах	Тайлбар:
1	13.4.1. Орон нутгийн өмчийн газрыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах асуудлаар үүрэг чиглэл өгөх	Өөрчлөх: 13.4.1. Орон нутгийн өмчийн газарт холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах асуудлаар зөвлөмж, чиглэл хүргүүлэх.	Орон нутгийн өмчийн газар нь аймаг, нийслэлийн Засаг даргын харьяаны газар тул мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах бүрэн эрхийг Засаг даргад үлдээхийн тулд тухайн хэсгийг хасах. - хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах асуудлаар “үүрэг, чиглэл өгөх” гэснийг “зөвлөмж, чиглэл хүргүүлэх” гэж өөрчлөх саналтай.
2	17.3.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь бусдын өмчлөлд шилжүүлж үл болох орон нутгийн өмчийн жагсаалтыг батална.	Нэмэх: баталж, түүнд өөрчлөлт оруулна.	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь бусдын өмчлөлд шилжүүлж үл болох орон нутгийн өмчийн жагсаалтыг баталж, түүнд өөрчлөлт оруулна.
3	17 дугаар зүйл	Нэмэх: Иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь орон нутгийн өмчийн харилцааг зохицуулсан захиргааны хэм хэмжээний акт баталж, дагаж мөрдүүлнэ.	“Орон нутгийн өмчийн газар өмчийн удирдлагыг хэрэгжүүлэхэд Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас үйл ажиллагаандаа баримтлах журам, дүрмийг батлан мөрдүүлнэ” хэмээн чиг үүргийг нь тодруулах шаардлагатай гэсэн саналтай байна.
4	19.2. Аймаг, нийслэлийн Засаг дарга нь харьяа Орон нутгийн өмчийн газрын бүтэц, орон тооны дээд хязгаарыг тогтоож, даргыг Төрийн өмчийн хороотой зөвшилцөн томилж, чөлөөлнө.	Өөрчлөх: Аймаг, нийслэлийн Засаг дарга нь харьяа Орон нутгийн өмчийн газрын бүтэц, орон тооны дээд хязгаарыг тогтоож, даргыг томилж, чөлөөлөх асуудлыг Иргэдийн Төлөөлөгчдийн хуралтай зөвшилцөн томилж, чөлөөлнө.	Төрийн өмчийн хороотой зөвшилцөн томилж, чөлөөлнө гэснийг Иргэдийн Төлөөлөгчдийн хуралтай зөвшилцөн томилж, чөлөөлнө гэж өөрчлөх саналтай байна.

5	19.7.3. Энэ хуулийн 17.4, 18.1-д заасан асуудлаар дүгнэлт гаргах	Нэмэх: 19.7.3. дахь заалтын агуулгыг тодруулах шаардлагатай байна.	Хуулийн төслийн 19.7.3.-д Орон нутгийн өмчийн газар нь Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын шийдвэр болон Засаг даргын шийдвэрт дүгнэлт гаргах тухай тусгажээ. Үүнийг тодруулах шаардлагатай гэсэн саналтай байна.
6	19 дүгээр зүйл. Орон нутгийн өмчийн газар, түүний чиг үүрэг 19.3 Орон нутгийн өмчийн газар дараах чиг үүрэгтэй: 19.3.1, 19.3.2, 19.3.3...	Нэмэх: 19.3.4.-д Орон нутгийн өмчийн газар нь энэ хуульд заасан үндэслэлээр олж авсан хөрөнгийг бүртгэнэ.	Орон нутгийн өмчийн газар, түүний чиг үүрэгт хуульд заасан үндэслэлээр хөрөнгө бүртгэх асуудал орхигдсон байх тул энэ үүргийг нэмж оруулах. Учир нь Орон нутгийн өмчийн өмчлөгч болон өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгчид орон нутгийн өмчийг бусдын өмчлөлд шилжүүлэх, барьцаалуулах, ашиглуулах чиг үүргүүд хуульд тусгагдсан байна. Иймд данс бүртгэлд бүртгэх чиг үүргийг нэмэх шаардлагатай гэсэн саналтай байна.
7	19 дүгээр зүйл. Орон нутгийн өмчийн газар, түүний чиг үүрэг 19.3 Орон нутгийн өмчийн газар дараах чиг үүрэгтэй: 19.3.1, 19.3.2, 19.3.3...	Нэмэх: 19.3.5-д Орон нутгийн өмчийн газар нь орон нутгийн байгууллага, орон нутгийн нийтийн үйлчилгээний байгууллага, орон нутгийн өмчит компанийн хөрөнгийг эрх бүхий этгээдийн зөвшөөрлийг үндэслэн данс бүртгэлээс хасах шийдвэрийг гаргана.	Орон нутгийн өмчийн газар, түүний чиг үүрэгт орон нутгийн байгууллага, орон нутгийн нийтийн үйлчилгээний байгууллага, орон нутгийн өмчит компанийн хөрөнгийг эрх бүхий этгээдийн зөвшөөрлийг үндэслэн данс бүртгэлээс хасах шийдвэрийг гаргах чиг үүргийг нэмж оруулах. Учир нь Орон нутгийн өмчийн өмчлөгч болон өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгчид орон нутгийн өмчийг бусдын өмчлөлд шилжүүлэх, барьцаалуулах, ашиглуулах чиг үүргүүд хуульд тусгагдсан байна. Иймд данснаас хасах, актлах чиг үүргийг нэмэх шаардлагатай гэсэн саналтай байна.

8	24.1. Хуульд заасан тохиолдолд улсын орлого болгох, эсхүл төрийн өмчид шилжүүлэх тухай шийдвэрийн дагуу хураагдсан хөрөнгийг Төрийн өмчийн хороо энэ хуульд заасны дагуу дуудлага худалдаагаар борлуулж, олсон орлогыг улсын төсөвт төвлөрүүлнэ.	Нэмэх: Хуульд заасан тохиолдолд улсын орлого болгох, эсхүл төрийн өмчид шилжүүлэх тухай шийдвэрийн дагуу хураагдсан хөрөнгийг орон нутгийн өмчийн газар хуульд заасны дагуу дуудлага худалдаагаар борлуулж, олсон орлогыг улсын төсөвт төвлөрүүлнэ.	Орон нутгийн өмчийн газрын чиг үүргийн нэмэх саналтай байна.
---	--	---	--

---oOo---

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

В.ОЮУМАА

ХЯНАСАН:
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.БАЯСАЛМАА

БОЛОВСРУУЛСАН:
ӨМЧИЙН МЕНЕЖМЕНТ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Б.НАНДИН-ЭРДЭНЭ